



ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ

БАТЛАВ

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СУЛЖЭЭ

ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЗОЛБАЯР

2021 оны 03 сарын 19.....

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: TH-C99/2021

2021/03/17

- Захиалагч СҮХБААТАР ДҮҮРЭГ 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ
байгууллага:
- Хэрэглэгчийн нэр: Х.ЦЭЦЭГСҮРЭН
- Харилцах утас: 325176
1. Байршил: СБД-н 6-р хорооны нутаг дэвсгэрт.
2. Зориулалт: 2-р цэцэрлэгийн өргөтгелийн барилга
3. Холбооны хэрэгцээ: *Худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг шилжүүлэх*
4. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ТӨК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
5. Техникийн үндсэн нөхцөл:
- 5.1. Барилгын талбайд ХШ 3212-н хүрээний S-D 12-6-2 худгаас S-D 12-7 худаг хоорондын /1/ яндантай сувагчлал бүхий ТПП 50x2 кабель 1 ширхэг, L5T 12-6 худгаас S-C 12-7 худаг хоорондын /0+2/ яндантай сувагчлал бүхий ТПП 50x2 кабель 1 ширхэг, ТПП 20x2 кабель 2 ширхэг, ТПП 10x2 кабель 5 ширхэг, шилэн кабель 1 ширхэг тус тус орсон тул дараах байдлаар шилжүүлэх шаардлагатай.
- Үүнд:
- Шинээр хийх:
- Барилгажих талбайн гадна буюу зүүн дээд талд шинээр стандартын худаг сууринуулна.
 - Барилгажих талбайг тойруулан шинээр хийсэн худаг болон S-C 12-7 худгуудийг **110 мм-н 2 яндантай** сувагчлалаар холбоно.
- Барилгажих талбайгаас чөлөөлөх:
- S-D 12-6-2 худгаас S-D 12-7 худаг хоорондын /1/ яндантай сувагчлал, L5T 12-6 худгаас S-C 12-7 худаг хоорондын /0+2/ яндантай сувагчлал сувагчлалуудыг барилгын талбайгаас чөлөөлнө.
 - Шинээр хийх сувагчлалыг **1,0-1,2 метрийн** гүнд сууринуулах ба сувагчлалаар татагдсан одоо байгаа кабелиудыг шинээр хийсэн сувагчлалаар татна.
- 5.2. Кабелийг шилжүүлэх, сууринуулах цаг хугацаа, гүйцэтгэлийг ашиглалт хариуцсан газрын хяналтан дор гүйцэтгэнэ.
- 5.2. Холбооны ажлын зураг хийх явцад худаг сувагчлалаар явж байгаа кабелийн тодотголыг дахин авч ажлын зураг төсөвт тусгах шаардлагатай.
- 5.3. Энэ техникийн нөхцлийн дагуу кабель шугам, худаг сувагчлалыг **шилжүүлэх угсралтын ажлыг** гүйцэтгэж техникийн актаар хүлээлгэн өгсний дараа холбоожуулах техникийн нөхцлийг олгох болно.
- 5.4. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.
6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:
- 6.1. Шилжүүлэх трассыг газар дээр нь захиалагч байгууллагатай хамтран шалгаж трассыг сонгох.
- 6.2. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын

стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.

6.3. Ажлын зургийг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын холбоо хариуцсан мэргэжилтэн болон инженерийн шугам сүлжээний холбогдох албан тушаалтнаар хянуулан зөвшөөрөл авч баталгаажуулсан байх шаардлагатай.

7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 7.1. Баталгаажсан ажлын зургыг угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн баталгааг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ны УБ Хотын сүлжээний газрын Бүртгэл төлөвлөлтийн тасгийн ахлах инженерээс (Утас: 70112399) авсан байх.
- 7.2. Кабель шугамын угсралтын болон газар шорооны ажлыг эхлэхдээ УБ Хотын сүлжээний газрын ерөнхий инженерээс зөвшөөрлийг авч тухайн харьялагдах кабель шугамын тасгийн ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.
- 7.3. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харьялагдах тухайн кабель шугамын тасгийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
- 7.4. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулах.
- 7.5. Угсралтын ажил дууссаны дараа УБ хотын мэдээллийн санд трассын зургийг оруулсан байх шаардлагатай бөгөөд оруулсан тодорхойлолтыг техникийн актны хамт хүлээлгэж өгнө.

8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сувагчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:

- 8.1. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.
- 8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
- 8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.

9. Техникийн нөхцлийг СҮХБААТАР ДҮҮРЭГ 2 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ-н Эрхлэгчийн 2021 оны 2-р сарын 3-ны өдрийн 02 тоот албан бичгийг үндэслэн олгов.

10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу УБ Хотын сүлжээний газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.


11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга



Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер



Н.НАРАНБААТАР

Боловсруулсан :
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер



Д.БАЛМАА

БАТЛАВ
 УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТУГЭЭХ СУЛЖЭЭ
 ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААН КОМПАНИЙН
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН

(Signature)

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар *15/00282/21.*

2021 оны *03* сарын *30* өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	21-51-000072
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХОЁР ДУГААР ЦЭЦЭРЛЭГ Төрийн байгууллага - РД: 9086412,
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Сүхбаатар б-р хороо, .
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Цэцэрлэг
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Газар эзэмших эрхийн 2008-08-27-ны 0177721 тоот гэрчилгээ. 2) Архитектур төлөвлөлтийн ГБМЗХ2020/27-022 тоот даалгавар 3) СБД-ийн 2-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын загвар зураг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	150 кВА (тоогоор) /Нэг зуун тавь/ (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	35/6 кВ-ын Олимп дэд станцаас 6 кВ-ын Хуваарилах байгууламж РП-31 А, Б фидерийн ХТП-387 дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцэнд ШО-70 рубильник тоноглож кабель шугам татаж тэжээх.
-----	---

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Өөрийн байрны 0.4 кВ-ын щитэнд ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж, / УЗО/, DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон 5 А тоолуур, гүйдлийн трансформатор суурнуулах.
-----	--

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
4.2	Идэр ХТП-387 дэд өртөөний 0,4 кВ талын I секцийн тоноглолыг батлагдсан зурагын дагуу ШО-70 ячейкаар бүрэн шинэчилж солих.
4.3	Хаалттай дэд өртөөг өргөтгэж байгаатай холбогдуулан өргөтгөл хийсэн, буусан хуучин тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтооолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
4.4	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

4.5	Барилгын талбайд орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус тоноглолын талаар эзэмшигчээс зөвшөөрөл авах.
-----	---

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцэн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагчийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.6	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
5.7	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурvas дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.8	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.9	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.10	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төvtэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.
-----	--

Комиссын гишүүд:




Л.Ганзориг



Б.Азаяа



Т.Мөнхболд



А.Зоригт

Боловсруулсан:



Ж.Хадам

Б.Ганзориг



УБЦТС ТӨХК

ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН ТОДОРХОЙЛОЛТ

20.9.2021. оны 05 сарын 17.

№

Зураг төслийн захиалагч, объектийн байршил:

Убат. СБР-ийн бүр хэрэг 2-р шарталын дундажийн барьга.

Зураг төслийн гүйцэтгэгч: "ЭСТЛА" LLC

Зураг төслийн дугаар нэр: Шинэр: ЭЛ-23/2021

Зураг төөсөлд хийсэн тодруулга:

Огтлонцож буй шугам, тоноглол

1-р шот ХТП-269 → ХТП-387 хэрэгжүүлж 6кВ 1м км

2-р шот ХТП-387 → ХТП-147 хэрэгжүүлж 6кВ 1м км

3-р шот ХТП-387 → МЧИС-ийн 1 байр 0,4кВ 1м км

4-р шот ХТП-387 → 39-р байр хэрэгжүүлж 0,4кВ 1м км

5-р шот ХТП-387 → 47-р байр хэрэгжүүлж 0,4кВ 1м км

6-р шот ХТП-387 Асиро маур хэрэгжүүлж 0,4кВ 1м км

7-р шот ХТП-387 → 38-р байр хэрэгжүүлж 0,4кВ 1м км

8-р шот ХТП-387 → 44-р байр хэрэгжүүлж 0,4кВ 1м км

Жиг: Алиса энгийн гучир дот кв. хадгалсан
тандын тодорхойлах авалт З.Г.Бархадарын тандын тодорхойлах
шалгаруулалттай.

тус тус огтолж, давхцаж байна. "УБЦТС ТӨХК" Техникийн бодлого
шинэчлэлтийн хэлтэстэй зөвшилцэн холбогдох зөвшөөрлийг авсаны дараа
газар шорооны ажлыг гүйцэтгэх. Аливаа ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫГ эхлэхээс
өмнө ЗҮҮН ТҮГЭЭХ ТӨВӨӨР газар дээр нь дахин тодруулга хийлгэн хяналтанд
ажлыг гүйцэтгэх шаардлагатайг анхаар !!!.

Тодруулга хийсэн: Мэдээллийн сангийн инженер

/ Л.Орхон /

Цахилгаан дамжуулах кабель шугамын трассын тодруулга хийлгэсэн хэрэглэгчдэд өгөх зөвлөмж

- Кабель шугамаас 2 тийш 2м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд машин, механизм хэрэглэхийг хориглоно. Кабель шугамыг ЗТТ-ийн ажилтны хяналтан дор гараар ухаж ил гаргана.
- Газар доор байгаа хамгийн захын кабель шугамаас 2 тийш 5м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд цохилтот машин, механизм хэрэглэхийг хориглоно.
- Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх
- Хэмжилт хийж кабель шугамтай гэж тодорхойлсон цэгт кабель шугам илрээгүй тохиолдолд, мөн тусгагдаагүй кабель шугам илэрсэн үед хэмжилт хийлгэсэн техникчтэй эргэж холбоо барин дахин тодорхойлуулна.
- Кабель хайгч багажны мэдрэх чадвараас шалтгаалан заасан цэгт дулаан, цэвэр болон бохир усны труба, холбооны кабель шугам гарч болохоос гадна хүчдэлтэй болон хүчдэлгүй кабель шугам аль аль нь хамтдаа мэдрэгдэх тул анхаарах
- Санамсаргүй тохиолдлоор кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлсон инженертэй нэн яаралтай холбоо барих
- Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.
- Гадны ашиглалтын шугам сүлжээг / Авто замын гэрэл, цахилгаан тээвэр компани, Улаанбаатар төмөр зам / ашиглагч байгууллагаас авах
- Кабелийн тандалт хийсэн талбайд тодорхойлогдоогүй ЦДКШ гарч ирвэл ГША-ыг зогсоож ашиглагч байгууллагатай зөвшилцэж шийдвэр гарсны дараа ГША-г үргэлжлүүлнэ.

**ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН
ДАГУУ АЖИЛЛАНА УУ!!! БИДЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАНД
БАЯРЛАЛАА**